

Төрийн албаны зөвлөлийн  
2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн  
62 дугаар тогтоолын 33 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт  
оруулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-  
ны өдрийн хууль

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан  
огноо:

Байгууллагын нэр:

Гаалийн ерөнхий газар

Албан тушаалын нэр:

Эрэлч нохойн сургалтын төвийн дарга

Ажлын цаг

Ердийн ажлын цагийг богиносгосон

Хөдөлмөрийн нөхцөл:

Хөдөлмөрийн хортой нөхцөл

Нэгжийн нэр:

Эрэлч нохойн сургалтын төв

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Ахлах түшмэл, ТТ-3

Ажлын байрны албан ёсны байршил:

14193 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8  
дугаар хороо, Их тойруу 81-1

Онцгой нөхцөл:

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Гаалийн хяналтад эрэлч нохой ашиглах мэргэжлийн баг бүрдүүлэх, эрэлч нохойг бэлтгэх,  
сургах ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дунг агентлагийн  
даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- Гаалийн албанд эрэлч нохой хөтлөх онолын болон практик арга зүй эзэмшсэн мэргэшсэн багийг бүрдүүлэх;
- Албаны эрэлч нохой хөтлөх онол болон практикийг хөгжүүлэх, эрэлч нохойн тусlamжтай гаалийн хяналтын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Гаалийн албанд ашиглаж байгаа эрэлч нохойн үүлдрийн сонголт, нөхөн хангарт, эрүүл мэнд, үржүүлгийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
- Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцох.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгuur үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх - Г, Хянах - Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Гаалийн албанд эрэлч нохой ашиглах онолын болон практик арга зүй эзэмшсэн, гаалийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах;	Мэргэжил, арга зүйн зөвлөмжийн үр дүн гарсан байх	Г, Х
	2. Гаалийн албанд ажиллаж байгаа нийт албан хаагч наарт албаны нохой ашиглах арга зүйд сургаж, эрэлч нохойн сургалттай холбоотой мэдлэг мэдээлэл олгох.	Мэргэжил, арга зүйн зөвлөмжийн үр дүн гарсан байх	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Гаалийн байгууллагад албаны эрэлч нохой ашиглах бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх;	Бодлого шийдвэрийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	2. Албаны чадамж бүхий эрэлч нохойг сургах, сургалтын агуулга, арга зүй, стандартыг олон улсын төвшинд нийцүүлэн боловсруулах, батлуулан мөрдөж ажиллах;	Албаны сургалтын стандарт боловсронгуй болсон, хэрэгжилт хангагдсан байх	Г, Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	3. Гаалийн хяналтад албаны эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлэх, зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх, гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд эрэлч нохойгоор дэмжлэг үзүүлэх.	Эрэлч нохойгоор илрүүлсэн зөрчлийн тоо нэмэгдсэн байх	Х
	1. Гаалийн албанд ашиглаж байгаа эрэлч нохойн үүлдрийн сонголт, нөхөн хангарт, эрүүл мэнд, үржүүлгийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;	Үүлдэр дагнасан эрэлч ноходтой болсон байх	 2

	2. Олон улсын стандартад нийцсэн албаны эрэлч нохойн хоол хүнс, сургалтын байр, талбайг цэвэр, аюулгүй байлгах, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулах.	Холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байна.	Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын чиг үүрэг, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан нэгжийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдсан байна	Г, Х
	2. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил үүргийн хуваарийг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр гарган, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах;	Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд ажил үүрэг давхцахгүй, орхигдохгүй байхаар төлөвлөгөдсөн байна	Г, Х, Ш
	3. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодыг эрэлч нохойтой холбогдох асуудлаар удирдамж чиглэлээр хангаж, үүрэг даалгавар, зөвлөгөө өгөх, хяналт тавих, сургалт зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Х, Ш
	4. Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна	Г, Х
	5. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх ажилд хяналт тавих;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна	Г, Х
	6. Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой програм хангамжийн хөгжүүлэлт, мэдээллийн сангийн баяжуулалт хийх ажлыг удирдан зохион байгуулах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	X, Ш



	7. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох, хамт олныг хамруулах.	Хамт олныг хамруулан зохион байгуулсан арга хэмжээ, хурал, цуглааны тоо, үр дүн	Г, Х, Ш
--	--	---	---------

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- Мал эмнэлэг (0841),</li> <li>- боловсролын шинжлэх ухаан (0111),</li> <li>- эрх зүй (0421),</li> <li>- худалдаа (0416),</li> <li>- мал зүй (081101),</li> <li>- менежмент ба удирдахуй (041303, 041305, 041306, 041307).</li> </ul>		
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх		
Туршлага	Төрийн албананд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах;</li> <li>- санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>- нэгжийн албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах;</li> <li>- байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>- албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- нэн тэргүүний ажлыг тодорхойлоход чиглэл, зааварчилгаа өгөх;</li> <li>- цаг үеийн шинж чанартай, гэнэтийн үйл явдлыг зөв, оновчтой шийдвэрлэх.</li> </ul>	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- өгөгдөл/мэдээлэлд сууринсан шийдвэр гаргах, бүтэц, чиг үүргийн шинжилгээ хийх;</li> <li>- гаалийн хяналтад эрэлч нохой ашиглах мэргэжлийн баг бүрдүүлэх, эрэлч нохойг бэлтгэх, сургах ажлыг боловсронгуй болгох асуудлаар бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах;</li> <li>- тулгамдаж буй асуудалд шийдэл олох, түүний зэрэг, сөрөг үр дагаврын талаар дүн шинжилгээ хийх;</li> </ul>	
	Асуудал	<ul style="list-style-type: none"> <li>- албан тушаалын чиг үүргийн дагуу хариуцах ажлыг хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- сэтгэн бodoх, анализ хийх, хөрвөх чадвартай байх;</li> <li>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх, гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- мэдээлэл/мэдлэгийг үнэлэн, мэдээллийг түргэн, шуурхай үр дүнтэй нягтлан судалж, нэмэлт мэдээлэл шаардлагатай</li> </ul>	



	шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- эсэхийг тодорхойлох;</li> <li>- хүндрэлийг шийдвэрлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, шийдэл боловсруулах чадвартай удирдах болон гүйцэтгэх түвшний албан хаагчийг татан оролцуулах;</li> <li>- байгууллагын үйл ажиллагааны бүх төвшинд хүндрэлтэй асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх боломжийг хөхиулэн дэмжих.</li> </ul>
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>- албан хаагчдыг идэвхжүүлж, зорижуулах, урам зориг өгөх, багаа үр дүнтэй удирдах замаар байгууллагын зорилгодоо амжилттай хүрэх;</li> <li>- байгууллагын өөрчлөлтийн менежмент, түүний дотор шинэ технологи, инноваци нэвтрүүлэхэд дэмжклэг үзүүлэн, манлайлан ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, ёс зүйгээр бусдыг манлайлан, үлгэр дууриалал үзүүлэх;</li> <li>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, зөвлөмж өгөх, чиглүүлэх зэргээр үлгэрлэн, дэмжих ажиллах;</li> <li>- эерэг дулаан, нөхөрсөг уур амьсгалыг бий болгох;</li> <li>- нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх;</li> <li>- албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</li> <li>- мэдээллийн технологийн хэрэглээний мэдлэгтэй байх;</li> <li>- албан хаагчдад ажлын байран дээр тасралтгүй сурч хөгжих боломжийг бүрдүүлэх;</li> <li>- төрийн албан хаагчийн болон гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</li> <li>- Монгол хэл бичгийн мэдлэгийн төвшин нь албан ажлын шаардлагыг хангасан;</li> <li>- өөрийгөө бодитой үнэлэх чадвартай байж, өөрийн сургалт, хөгжлийн боломжит арга замуудыг таньж тогтоох.</li> <li>- өөрийн мэдлэг, чадвар, өөрт байгаа мэдээллийг баг, хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах;</li> <li>- багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах;</li> <li>- харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан, мэдээллийг хүргэх, түгээх.</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Гаалийн ерөнхий газрын дарга, дэд дарга, Хяналт, бүрдүүлэлтийн газрын дарга.



Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Гаалийн улсын ахлах байцаагч 1
- Гаалийн улсын байцаагч 4
- Төрийн үйлчилгээний албан хаагч 11

Нийт: 16

Бусад харилцах субъект:


- Төрийн болон төрийн бус байгууллагын холбогдох ажилтан;
- Иргэн, хуулийн этгээд;
- Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодын дарга, орлогч дарга, албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан.

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт  
боловсруулсан:

Албан тушаал:

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ТАМИРАА  
  
(Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)

20<sup>18</sup> оны 4 сарын 11-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,  
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын  
шийдвэр:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 23 0309

Дугаар: 062

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА.....R.ОТГОНЖАРГАЛ

(Гарын үсэг)

(Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)

20<sup>18</sup> оны 09 дугаар сарын 11-ны өдөр

